

## 6- р сар

- I. Төсвийн орлого
- II. Төсвийн зарлага
- III. Төсвийн орлого, /сумаар/
- IV. Банкны кассын орлого зарлага, зээл хадгаламж
- V. Ажил хайгч иргэд
- VI. Бүртгэлтэй ажилгүйчүүд, ажлын байрны зуучлал
- VII. Нийгмийн даатгалын орлого тэтгэврийн санхүүжилт
- VIII. Нийгмийн даатгалын орлого, зарлага
- IX. Нийгмийн даатгал заавал даатгуулагчийн тоо
- X. Хүн амын ердийн хөдөлгөөн, хүүхдийн эндэгдэл
- XI. Эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
- XII. Хэрэглээний үнийн индекс
- XIII. Гол нэрийн бүтээгдэхүүний үнэ
- XIV. Аж үйлдвэр
- XV. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн
- XVI. Нийгмийн халамж
- XVII. Гэмт хэргийн мэдээ
- XVIII. Гэмт хэрэг зөрчил (сумдаар)

## Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2019 оны 6-р сарын байдлаар)

### I. Төсвийн орлого



Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2019 оны 6 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 95.0 хувьтай буюу 3625.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 125.4 хувьтай буюу 1055.1 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 4681.0 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 100.5 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 24207.0 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 102.5 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 5881.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 13091.1 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1537.9 сая төгрөг, хандив тусламжаас 70.3 сая төгрөг нийт 20581.1 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөгөө Дэрэн, Баянжаргалан, Гурвансайхан, Хулд, Сайнцагаан сумд 7.7-25.1 хувиар буюу 5.5-67.0 сая төгрөгөөр тасалдуулсан бол бусад сумд 1.9-155.3 хувиар буюу 1.1-167.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

### II. Төсвийн зарлага



2019 оны 6 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 21284.4 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 14.2 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 12487.3 сая төгрөг болж нийт зардлын 58.7 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 28.3 хувиар өсч 1545.9 сая төгрөг болжээ. Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал бусад урсгал шилжүүлэг 71.3 хувиар буурч 578.2

сая төгрөг болсон бол бусад бүх зардал 4.2-92.7 хувиар буюу 19.7-691.2 сая төгрөгөөр өссөн байна.

### III. Банк



Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 19.8 хувиар өсч 113252.2 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 725.5 сая төгрөг, чанаргүй зээл 1118.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 31.6 хувиар, чанаргүй зээл 24.5 хувиар тус тус өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 1.6 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 28.6 хувиар өсч 65998.3 сая төгрөг болов.

### IV. Бүртгэлтэй ажилгүйчүүд



2019 оны 6 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 526 хүн бүртгэгдсэн нь өмнөх сараас 90 хүнээр өссөн байна. Нийт ажилгүйчүүдийн 46.2 хувь буюу 243 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 173 ажил хайгч иргэн ногдож байхад Говь-Угтаал 454, Луус 287, Хулд 261, Баянжаргалан 188, Цагаандэлгэр 436, Өндөршил 361 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.

### V. Ажлын байрны зуучлал



ХХҮГазрын 2019 оны 6 сарын мэдээгээр нийт 309 хүн ажлын байранд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 93 хүнээр өссөн байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд уул уурхайн салбарт 25.6 хувь, хөдөө аж ахуйн салбарт 18.8 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 20.7 хувь, боловсролын салбарт 6.5 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 1.0 хувь, цахилгаан эрчим хүчний салбарт 1.3 хувь, урлаг үзвэр тоглоомын салбарт 2.9 хувь үйлчилгээний бусад салбарт 12.9 хувь, хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 4.2 хувь зуучлагдсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 114 нь буюу 36.9 хувь нь эмэгтэйчүүд байна.



## **VI. Нийгмийн халамж**

2019 оны эхний 6 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 14583 хүнд 3326.3 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна. Нийт тэтгэвэр тэтгэмж авагчдын 30.2 % буюу 4461 нь алдарт эхийн одонтой эхчүүд бөгөөд 614.8 сая төг, 16.5 % буюу 2406 нь насны хишиг тэтгэмж авч буй ахмадууд 218.9 сая төг, 24.2 % буюу 3526 нь 0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүд болон олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх, жирэмсэн эмэгтэйчүүдэд 777.4 сая төг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 1593 иргэнд 577.4 сая төгрөг, Халамжийн тэтгэврийг 762 иргэнд 782.9 сая төгрөгийг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг 1117 иргэнд 158.7 сая төгрөгийн тусламжийг үзүүлсэн бол бусад төрлийн тусламж үйлчилгээнд 718 иргэнийг хамруулан 196.1 сая төгрөгийг зарцуулжээ.

## **VII. Нийгмийн даатгал**



Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны эхний 6 сарын байдлаар 17507.1 сая төгрөг, зарлага 16824.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 2746.6 сая төгрөгөөр өсч, зарлага 2222.2 сая төгрөг буюу 15.2 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2019 оны эхний 6 сарын байдлаар 9990 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2094 хүн буюу 21.0 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 3816 хүн буюу 98.2 хувь нь төсөвт байгууллагаас, 4080 хүн буюу 40.8 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж ахуй нэгж, байгууллагын даатгуулагч, сайн дурын даатгуулагч, төсөвт байгууллага өссөн байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2019 оны эхний 6 сарын байдлаар 14492.4 сая төг болж, үүний 83.6 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.7 хувийг тэжээгчээ алдсаны, 3.2 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны эхний 6 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 7085 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 82.3 хувь буюу 5831 хүн өндөр насны, 12.6 хувь буюу 890 хүн тахир дутуугийн, 3.2 хувь буюу 231 хүн тэжээгчээ алдсаны, 1.9 хувь буюу 133 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Энэ оны эхний 6 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 1253, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 25 ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 103 хүн байна.

Эхний 6 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 30131 байгаагийн 81.3 хувь буюу 24502 төр хариуцах иргэд, 12.9 хувь буюу 3896 малчид, 4.2 хувь буюу 1282 аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.5 хувь буюу 451 оюутан суралцагсад байна. 2019 оны 6 сарын байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 6175.0 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 33.4 хувиар буюу 1545.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө Гурвансайхан сумаас бусад бүх сумд давуулан биелүүлсэн байна.

### **VIII. Эрүүл мэнд**



Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2019 оны 6-р сарын байдлаар 440 эх төрсөн ба нийт 446 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 34 тохиолдлоор буурсан байна. Төрсөн эхчүүдийн 98.4 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд, 0-1 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл Эрдэнэдалай суманд 1 гарсан байна. Нас баралтын 121 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 14 тохиолдлоор буурчээ. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт хамгийн өндөр буюу 31.4 хувийг эзэлж 38 хүн нас барсан байна.

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 5811 эмчлүүлэгч хэвтэж, 5815 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 42220 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.3 байна. 2019 оны 6 сарын байдлаар 93547 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 31.9 %, амбулаторийн үзлэг 46.1 %, идэвхтэй хяналт 15.1 %, гэрийн үзлэг 5.0 %- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 35.9 хувь нь эрэгтэй, 64.1 хувь нь эмэгтэй хүн байна. Халдварт өвчний 238 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 13 тохиолдлоор өсч, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 51.7 болж өмнөх оны мөн үеэс 2.7 пунктээр өссөн байна

## **IX. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс**

Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхийнхийг биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2019 оны 6-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2018 оны 6-р сартай харьцуулахад 5,5 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн индекс 5,5 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 9,3 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 6,7 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 6.4 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 0.3 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 5,2 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 7,9 хувь, тээврийн бүлэг 5,4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

2019 оны 6 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин , дизель түлш болон ноолуурын үнийг орууллаа.

### **ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/**

<b>№</b>	<b>Барааны нэр, төрөл</b>	<b>VI/5</b>	<b>VI/12</b>	<b>VI/19</b>	<b>VI/26</b>
1	Гурил, 1-р зэрэг, кг	1200	1200	1200	1200
2	Хонины мах, кг	9000	9000	8500	8500
3	Үхрийн мах, кг	0	0	0	0
4	Ямааны ястай мах, кг	8200	8500	8200	8000
5	Элсэн чихэр, кг	1880	1880	1880	1880
6	Цагаан будаа, кг	2310	2310	2280	2280
7	Шингэн сүү, л	3000	3000	2500	2500
8	Ноолуурын үнэ 1 кг	82500	80000	80000	80000
9	Бензин А-80, 1литр	1890	1890	1850	1860
10	Бензин А-92, 1литр	2020	2020	1970	1970
11	Дизель түлш 1 литр	2360	2320	2320	2320

## **Х. Аж үйлдвэр**



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2019 оны 6 сарын байдлаар 4241.1 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 12.4 хувиар өссөн байна

## **ХI. Гэмт хэрэг**



Цагдаагийн хэлтсийн 2019 оны 6 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 112 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29.1 хувь болж буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогчдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13.8 хувиар буурч 56 хүн холбогдоод байна. 2019 оны 6 сарын байдлаар танхайрах, булаалт, албан тушаал, хүнийг санаатай хөнөөх гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс малын хулгайн хэрэг, залилангийн гэмт хэргүүд өссөн байна. Харин тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, бусдын эд хөрөнгийн хулгай, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, бусад хэрэг буурсан байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 16.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 28.6 хувийг бусдын эд хөрөнгийн хулгайн хэрэг, 0.9 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг, 8.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын эсрэг гэмт хэрэг, 0.9 хувийг дээрмийн хэрэг, 3.5 хувийг хүчингийн хэрэг, 21.4 хувийг малын хулгайн хэрэг, 11.6 хувийг залилангийн хэрэг, 8.1 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн 14.3 хувийг согтуугаар, 4.5 хувийг бүлэглэж, 11.6 хувийг хүүхэд оролцсон, 9.8 хувийг эмэгтэй хүн оролцон үйлдсэн хэрэг эзэлж байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 37 хүн байхад Дэрэн 72, Сайнцагаан 55, Дэлгэрцогт 53, Баянжаргалан 49 байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 300.3 сая төгрөг, түүний 27.5 хувь буюу 82.6 сая төгрөгийг нөхөн төлүүлээд

байна. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар өсч, 46.2 хувь болсон байна.

## **XII. Хөдөө аж ахуй**



Аймгийн хэмжээгээр энэ оны эхний хагас жилийн байдлаар оны эхний төллөх насны хээлтэгч малын 77.1 Хувь буюу 1275.0 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төл 99.4 хувь буюу 1270.3 мянган төл бойжиж байна. өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төлөлсөн хээлтэгч 7.2 хувь, бойжсон төл 15.0 хувиар тус тус өссөн байна. Аймгийн хэмжээнд энэ оны эхний хагас жилийн байдлаар 7492 толгой мал хорогдоод байна. Үүний 72.5 хувь нь ямаа, 23.9 хувь нь хонь, 3в6 хувийг бод малын хорогдол эзэлж байна. Нийт хорогдсон том малын 22.4 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

### **Тариалсан талбай**

2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 21.8 га талбайд төмс, 14.4 га-д хүнсний ногоо, 0.3 га-д тэжээлийн ургамал байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төмс 13.5 хувь, хүнсний ногоо 9.5 хувиар тус тус өссөн байна.

## **XIII. Байгаль орчин**



### **ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ**

Агаарын температурын сарын дундаж нь нийт нутгаар 18-26 градус дулаан буюу ихэнх нутгаар ОЖД-н орчим байх төлөвтэй. Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлийн хагас, гуравдугаар арав хоногийн эхээр бага зэрэг сэрүүсч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 9-14 градус, өдөртөө 19-24 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 13-18 градус, өдөртөө 23-28 градус дулаан байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 16-21 градус, өдөртөө 28-33 градус дулаан байх ба нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим нутгаар өдөртөө 31-36 градус хүрч халах төлөвтэй.

Энэ сард нийт нутгаар олон жилийн дунджийн орчим бороо орох төлөвтэй. Нэг ба хоёрдугаар арав хоногийн эх болон сүүлчээр зарим газраар бороо, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үе, сүүлчээр нутгийн хойд хэсгээр түр зуурын бороо орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Борооны өмнө зарим газраар салхи түр зуур ширүүснэ.

I.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, мянган төгрөгөөр  
2019.07.10

Үзүүлэлт	мөр	2018 VI	2019 VI			19/18
			төл	гүйц	хувь	хувь
Нийт орлого /тусламжийн дүн/	1	22550817.6	23619022.8	24206973.4	102.5	107.3
А.УРСГАЛ ОРЛОГО	2	3674726.1	3769986.1	3599330.2	95.5	97.9
I.ТАТВАРЫН ОРЛОГО	3	2169477.6	1811125.8	2000457.1	110.5	92.2
1.1 Хүн амын орлогын албан татвар	4	1541965.2	1174235.5	1433876.4	122.1	93.0
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар	5	1539438.1	1433031.2	1650496.0	115.2	107.2
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	6	-427269.9	-450000.0	-378123.9	84.0	-
1.2 үйл ажиллагааны орлого	7	294461.8	170204.3	99686.4	58.6	33.9
1.3 Хөрөнгө борлуулсаны	8	16798.2	21000.0	11590.6	55.2	69.0
1.5 Бусад татвар	9	118537.0	0.0	50227.3	-	42.4
2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/	10	64990.1	68867.3	48455.5	70.4	74.6
3. Авто тээврийн хэрэгслийн	11	218772.0	298720.0	241497.8	0.0	110.4
4. Бусад татвар	12	343750.3	269303.0	276627.4	102.7	80.5
4.1 Улсын тэмдэгийн	13	98295.2	84660.0	73873.5	87.3	75.2
4.2 Ашигт малтмал нөөцийн	14	40270.0	7650	15073.5	197.0	37.4
4.3 Газрын төлбөр	15	119490.4	86933.0	102470.4	117.9	85.8
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	16	8982.6	37920.0	8256.2	21.8	91.9
4.6 Усны төлбөр	17	27299.1	10300.0	20264.8	196.7	74.2
4.6.Бусад	19	49413.0	41840.0	56689.0	135.5	114.7
II.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20	1505248.5	1958860.3	1598873.1	81.6	101.6
2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого	21	1244090.5	1551361.2	950375.8	61.3	76.4
2.2 Бусад нэр заагдаагүй	22	261158.0	407499.1	648497.3	159.1	248.3
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	23	30480.8	46500.0	26568.0	57.1	87.2
V.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	24	18845610.7	19802536.7	20581075.2	103.9	109.2
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	25	3994094.3	4981886.2	5881886.2	118.1	147.3
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	26	13633672.8	13091066.6	13091066.6	100.0	96.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих	27	1217843.6	1576724.3	1537869.1	97.5	126.3
Хандив тусламж	28	0.0	152859.6	70253.3	46.0	-
Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /	29	3705206.9	3816486.1	3625898.2	95.0	97.9
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	30	639355.2	677490.0	927961.2	137.0	145.1
Аймгийн нийт орлого	31	4344562.1	4493976.1	4553859.4	101.3	104.8

II.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2019.07.10

Зарлагын төрөл	2018 VI	2019 VI			2019 VI /2018 VI
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Орон нутгийн байгууллагын зарлагын дүн	18634432.3	27926653.5	21284433.6	76.2	114.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10191517.6	13490268.5	12487274.9	92.6	122.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1205356.0	1685992.7	1545887.4	92.6	128.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1892852.1	2535193.8	2320499.5	91.7	122.6
Хангамж бараа материалын зардал	330804.6	510899.5	389632.7	76.3	117.8
Норматив зардал	589936.9	885859.9	617482.0	69.7	104.7
Эд хогшил урсгал засварын зардал	154761.6	378989.4	229416.1	60.5	148.2
Томилолтын зардал	74857.4	174612.8	139559.0	79.9	186.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	470964.0	879476.8	490634.6	55.8	104.2
Бараа үйлчилгээний бусад зардал	745448.9	4413711.1	1436601.6	32.5	192.7
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.0	125149.7	125149.7	100.0	-
Засгийн газрын дотоод шилжүүлэг	115393.2	0.0	0.0	-	0.0
Бусад урсгал шилжүүлэг	2013469.1	339550.5	578189.3	170.3	28.7
Хөрөнгийн зардал	849070.9	2506948.8	924106.8	36.9	108.8

### III. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

Сумд	2019 I-VI			2019 VI сар		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Дэлгэрцогт	58030.5	59147.4	101.9	14122.9	12521.1	88.7
Дэрэн	71857.9	66340.4	92.3	16428.2	13044.9	79.4
Говь-Угтаал	107837.8	275280.1	255.3	23983.7	39867.0	166.2
Цагаандэлгэр	38633.1	44769.8	115.9	8665.7	10266.0	118.5
Баянжаргалан	264538.3	197531.5	74.7	86159.5	18953.7	22.0
Өндөршил	80541.2	81806.6	101.6	18143.0	18592.1	102.5
Гурвансайхан	177779.6	141212.4	79.4	61536.9	37896.2	61.6
Өлзийт	130356.8	174090.9	133.5	21020.0	16431.9	78.2
Хулд	118144.3	97750.4	82.7	20610.0	22978.5	111.5
Луус	75518.0	98913.4	131.0	15201.7	15736.6	103.5
Дэлгэрхангай	88266.7	134438.1	152.3	20110.0	18566.5	92.3
Сайхан-Овоо	57864.6	64218.2	111.0	14840.0	11568.9	78.0
Эрдэнэдалай	153506.6	166586.5	108.5	26024.0	37846.9	145.4
Сайнцагаан	412281.7	355166.3	86.1	83430.0	84732.7	101.6
Адаацаг	72051.4	89608.2	124.4	14135.0	17714.6	125.3
Дундговь	1203736.4	1697383.9	141.0	339626.4	390805.5	115.1
Дүн	3110944.9	3744244.1	120.4	784037.0	767523.1	97.9

**IV.БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА, ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН  
МЭДЭЭ, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр**

Үзүүлэлт	ХААН банк		Хас банк		Төрийн банк		Капитал банк		Бүгд		
	2018 VI	2019 VI	2018 VI	2019 VI	2018 VI	2019 VI	2018 VI	2019 VI	2018 VI	2019 VI	2019 / 2018 хувь
Кассын орлого	8,628.9	7,194.2	607.8	88.6	4076.2	3286.0	0.0	0.0	13312.9	10568.8	79.4
Зузаатгал аар											
Кассын зарлага	6,030.6	4,503.5	2233.8	2302.3	4526.3	3892.0	105.5	0.0	12896.2	10697.8	83.0
шилжүүлсэн											
Зээлийн өрийн үлдэгдэл	56379.9	57300.1	11176.7	12802.5	26946.7	43149.6	62.7	0.0	94566.0	113252.2	119.8
үүнээс: Анхаарал хандуулах зээл	269.2	298.0	183.8	354.8	98.2	72.7	0.0	0.0	551.2	725.5	131.6
чанаргүй зээл	381.6	355.7	460.7	539.2	38.4	223.4	17.4	0.0	898.1	1118.3	124.5
Нийт хадгаламжийн үлдэгдэл	34915.9	45432.7	3906.4	4877.0	11730.6	15738.7	593.3	0.0	51146.2	66048.4	129.1

## V. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2019.07.10

Сум	Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам	Тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд	Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд	Үүнээс эмэгтэй	Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд
Дэлгэрцогт	1101	3	9	2	82
Дэрэн	1365	15	16	9	117
Говь-Угтаал	1057	40	48	24	454
Цагаандэлгэр	688	28	30	12	436
Баянжаргалан	800	15	24	7	300
Өндөршил	970	35	35	15	361
Гурвансайхан	1417	27	28	7	198
Өлзийт	1628	2	1	1	6
Хулд	1608	44	42	17	261
Луус	1255	35	36	11	287
Дэлгэрхангай	1475	21	25	12	169
Сайхан-Овоо	1442	32	28	16	194
Эрдэнэдалай	3708	5	72	45	194
Сайнцагаан	10057	108	112	55	111
Адаацаг	1899	26	20	10	105
Дүн	30470	436	526	243	173

## ҮІ. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2019 оны эхний 6 сарын байдлаар

2019.07.10

Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	58.0	17.0	18.8
Уул уурхай олборлох үйлдвэр	79.0	9.0	25.6
Боловсруулах аж үйлдвэр	1.0	1.0	0.3
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	4.0	0.0	1.3
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	0.0	0.0	0.0
Барилга	8.0	0.0	2.6
Бөөний ба жижиглэн худалдаа	3.0	2.0	1.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Зочид буудал, зоогийн газар	0.0	0.0	0.0
Мэдээлэл холбоо	0.0	0.0	0.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	4.0	3.0	1.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	64.0	30.0	20.7
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	6.0	2.0	1.9
Боловсрол	20.0	11.0	6.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	13.0	13.0	4.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	9.0	5.0	2.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	40.0	21.0	12.9
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
<b>Бүгд</b>	<b>309.0</b>	<b>114.0</b>	<b>100.0</b>

VII. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

2019.07.05

/сая.төг/

	2018 оны YI сар	2019 оны YI сар			<u>2019 YI</u> <u>2018 YI</u> хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийгмийн даатгалын сангийн орлого	14760.5	4629.9	17507.1	378.1	118.6
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	12778.9	3824.9	15116.1	395.2	118.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	638.3	409.6	712.9	174.0	111.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн	961.7	0.0	1171.9	#DIV/0!	121.9
YOMШӨ*-ний даатгалын сангийн	244.5	327.9	366.9	111.9	150.1
Ажилгүйдлийн даатгалын сангийн	137.1	67.5	139.3	206.4	101.6
Нийгмийн даатгалын сангийн зарлага	14601.8	16036.0	16824.0	104.9	115.2
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	12522.7	14821.0	14494.2	97.8	115.7
Тэтгэмжийн даатгалын сангийн	636.9	720.3	645.5	89.6	101.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1074.4	0.0	1172.4	#DIV/0!	109.1
YOMШӨ*-ний даатгалын сангийн	239.8	316.3	355.5	112.4	148.2
Ажилгүйдлийн даатгалын сангийн	128.0	178.4	156.4	87.7	122.2

Тайлбар: \*Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

VIII.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВРИЙН САНХҮҮЖИЛТ, 2019 оны  
эхний 6 сарын байдлаар

2019.07.05

Сумд	Н.Д.Шимтгэлийн орлого /мян.төг/			Тэтгэврийн санхүүжилт /мян.төг/		
	төл	гүйц	хувь	олгох	олгосон	хувь
Дэлгэрцогт	103181.0	152883.1	148.2	597350.4	597350.4	100.0
Дэрэн	104957.1	161469.7	153.8	656484.5	656484.5	100.0
Говь-Угтаал	121769.6	194803.6	160.0	520674.8	520674.8	100.0
Цагаандэлгэр	75702.4	118100.0	156.0	295435.1	295435.1	100.0
Баянжаргалан	119036.3	217381.2	182.6	312442.4	312442.4	100.0
Өндөршил	109560.4	163241.4	149.0	411166.5	411166.5	100.0
Гурвансайхан	185243.8	178295.1	96.2	554741.1	554741.1	100.0
Өлзийт	128069.7	225420.3	176.0	729660.9	729660.9	100.0
Хулд	147113.6	214832.1	146.0	690937.1	690937.1	100.0
Луус	119465.6	195100.0	163.3	588375.5	588375.5	100.0
Дэлгэрхангай	142436.6	219557.7	154.1	667959.3	667959.3	100.0
Сайхан-Овоо	106340.9	146780.6	138.0	548788.9	548788.9	100.0
Эрдэнэдалай	294818.9	459847.1	156.0	1726741.2	1726741.2	100.0
Адаацаг	139167.5	205031.1	147.3	768186.1	768186.1	100.0
Сайнцагаан	2733067.4	3322247.5	121.6	5466576.5	5466576.5	100.0
Дүн	4629930.8	6174990.5	133.4	14535520.3	14535520.3	100.0

IX. НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ

2019.07.05

Үзүүлэлтүүд	2017 оны ҮИ сар	2018 оны ҮИ сар	2019 оны ҮИ сар	$\frac{2019 \text{ VI}}{2018 \text{ VI}}$ хувь
Заавал даатгуулагчийн тоо	9723	9513	9990	105.0
Үүнээс:				
Аж ахуйн нэгж, байгууллага	2118	1952	2094	107.3
Төсөвт байгууллага	3787	3803	3816	100.3
Сайн дурын	3818	3758	4080	108.6
Олгосон тэтгэвэр, сая төг	11033.1	12561.6	14492.4	115.4
Үүнээс:				
Өндөр настны	9093.4	10282.4	12109.1	117.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	1308.6	1514.5	1522.3	100.5
Тэжээгчээ алдсаны	327.1	377.3	393.0	104.2
Цэргийн	304.0	387.4	468.0	120.8

## X. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

2019.07.06

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		0-5 насны хүүхдийн эндэгдэл	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Дэлгэрцогт	0	0	5	4	1	0	1	0
Дэрэн	3	1	7	2	0	0	0	0
Говь-Угтаал	5	6	3	2	0	0	0	0
Цагаандэлгэр	0	1	3	1	0	0	1	0
Баянжаргалан	0	0	2	3	0	0	0	0
Өндөршил	2	1	2	3	0	0	0	0
Гурвансайхан	0	0	7	2	0	0	0	0
Өлзийт	1	8	2	3	0	0	0	0
Хулд	4	0	6	6	1	0	0	0
Луус	2	3	5	5	0	0	0	0
Дэлгэрхангай	7	8	12	8	0	0	0	0
Сайхан-Овоо	1	3	5	8	0	0	0	0
Эрдэнэдалай	15	9	13	23	0	1	0	1
Сайнцагаан	433	401	55	41	2	0	4	0
Адаацаг	7	5	8	10	0	0	0	0
Дүн	480	446	135	121	4	1	6	1

ХИ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

2019.07.06

Сумд	Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо		Бүгд үзлэг		Бүртгэгдсэн бүх өвчлөл		Халдварт өвчин бүгд		үүнээс /зарим үзүүлэлтээр/			
									сүрьеэ		вируст гепатит	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Дц	142	163	889	1084	142	165	22	5	0			
Дн	102	85	1511	1056	189	304	4	2				
Гу	110	123	2165	2131	189	1083	3	6	1			
Цд	98	75	1101	718	182	95	0	0				
Бж	102	139	1687	899	167	107	0	1				
Өш	152	154	1931	1626	168	133	4	1				
Гс	103	104	1689	1575	267	329	4	6	1	1		
Өт	60	82	2009	2179	91	173	4	12		2	1	1
Хд	117	106	1718	882	138	462	2	9		1		
Лс	137	124	1437	2230	92	92	8	4		1	1	
Дх	79	97	1957	1030	53	53	2	4		1		
Со	115	79	1210	535	465	242	3	2	1	0	1	
Эд	341	282	4956	5686	666	1322	2	12	2	3		
Ад	167	182	4648	2690	241	250	3	9	2	1		
Сц	3222	3032	57767	67730	5751	12572	164	165	8	5	2	0
Мд	265	243	271	188	0	0	0	0				
Эб	196	278	147	244	0	0	0	0				
МУЭ төв	465	467	1125	1064	295	335	0	0				
ДҮН	5973	5815	88218	93547	9096	17717	225	238	15	15	5	1

\* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

## XII. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

2019.07.10

Барааны бүлгээр	<u>2019 VI</u> 2018 VI	<u>2019 VI</u> 2018 XII
<b>ЕРӨНХИЙ ИНДЭКС</b>	<b>105.5</b>	<b>103.6</b>
<b>01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА</b>	<b>109.3</b>	<b>112.4</b>
01.1 ХҮНСНИЙ БАРАА	<b>110.2</b>	<b>113.9</b>
01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА	<b>108.7</b>	<b>107.4</b>
01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН	<b>116.1</b>	<b>141.9</b>
01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН	<b>112.7</b>	<b>114.3</b>
01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ	<b>91.6</b>	<b>83.3</b>
01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС	<b>99.7</b>	<b>99.3</b>
01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ	<b>130.9</b>	<b>113.0</b>
01.1.7 ХҮНСНИЙ НОГОО	<b>104.3</b>	<b>122.9</b>
01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР	<b>104.7</b>	<b>101.5</b>
01.1.9 ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН	<b>98.6</b>	<b>100.9</b>
01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	<b>98.2</b>	<b>95.6</b>
<b>02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС</b>	<b>106.7</b>	<b>104.6</b>
02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА	<b>106.5</b>	<b>104.3</b>
02.2 ТАМХИ	<b>107.0</b>	<b>105.1</b>
<b>03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ</b>	<b>106.4</b>	<b>102.0</b>
03.1 ХУВЦАС, БӨС БАРАА	<b>107.6</b>	<b>102.6</b>
03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА	<b>124.7</b>	<b>106.3</b>
03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС	<b>105.9</b>	<b>102.2</b>
03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ	<b>100.0</b>	<b>100.0</b>
03.2 ГУТАЛ	<b>103.8</b>	<b>100.8</b>
<b>04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ</b>	<b>100.3</b>	<b>99.7</b>
04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС	<b>125.0</b>	<b>100.0</b>
04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	<b>104.9</b>	<b>100.8</b>
04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	<b>100.0</b>	<b>100.0</b>
04.5 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	<b>97.6</b>	<b>99.2</b>

Барааны бүлгээр		2019 VI 2018 VI	2019 VI 2018 XII
<b>05.</b>	<b>ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА</b>	<b>105.2</b>	<b>101.8</b>
	05.1 ГЭР АХУЙН ТАВИЛАГ, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	106.0	102.2
	05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	101.9	100.0
	05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	96.9	101.4
	05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	105.1	99.3
	05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГС:	101.6	100.3
	05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУСА	110.3	103.1
<b>06.</b>	<b>ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>107.9</b>	<b>100.5</b>
	06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙНИ ХЭРЭГСЭЛ	109.2	100.5
	06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
	06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
<b>07.</b>	<b>ТЭЭВЭР</b>	<b>105.4</b>	<b>99.9</b>
	07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	102.0	101.9
	07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ	108.2	96.7
	07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	133.8	101.2
<b>08.</b>	<b>ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>101.5</b>	<b>100.0</b>
	08.2 ТЕЛЕФОН АППАРАТ, ФАКСЫН ХЭРЭГСЭЛ	100.0	100.0
	08.3 ТЕЛЕФОН УТАС, ФАКСЫН ҮЙЛЧИЛГЭЭ	101.6	100.0
<b>09.</b>	<b>АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>104.3</b>	<b>102.7</b>
	09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨЙ	104.4	102.3
	09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.3	100.3
	09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	107.7	105.0
<b>10.</b>	<b>БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>11.</b>	<b>ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>107.6</b>	<b>101.8</b>
	11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	106.9	104.8
	11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	108.0	100.0
<b>12.</b>	<b>БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>102.9</b>	<b>104.4</b>
	12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	102.4	104.8
	12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	107.2	104.6
	12.5 ДААТГАЛ	100.0	100.0
	12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0

**ХИИ.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН МЭДЭЭ, 2019 оны 6 сарын байдлаар**  
**мян.төг**

2019.07.10

<b>Халамжийн төрөл</b>	<b>хамрагдсан хүн</b>	<b>Мөнгөн дүн</b>
<b>Нийгмийн халамжийн тэтгэвэр</b>	<b>762</b>	<b>782,933</b>
Ахмад настны тэтгэвэр	43	42,166
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	515	476,304
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр		-
Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд	204	264,463
Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэвэр		
<b>Нийгмийн халамжийн тэтгэмж</b>	<b>1,593</b>	<b>577,408</b>
<i>Асаргааны тэтгэмж</i>	<b>919</b>	<b>374,184</b>
<i>Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан болон эрсдэлт</i>	31	15,042
<i>Гэр бүлийн тухай хүүлийн 25.5-д заасан болон</i>	2	1,116
<i>Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон</i>	<b>4</b>	<b>1,312</b>
<i>Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэний</i>	4	1,312
<i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэртээ асрамжилж</i>		
<i>Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа</i>	<b>882</b>	<b>356,714</b>
<i>Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн</i>	152	57,934
<i>Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг</i>	568	234,386
<i>Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн</i>	162	64,394
<i>Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа шаардлагатай</i>		
<b>Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн</b>	<b>674</b>	<b>203,224</b>
<i>Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх</i>	8	9,600
<i>18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24</i>		
<i>Хорих ангиас сүллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй,</i>	1	1,200
<i>Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй</i>		
<i>Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны</i>	165	144,064
<i>Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш</i>	500	48,360
<b>Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж</b>	<b>4461</b>	<b>614,800</b>
<b>Хүүхдийн мөнгөн тэтгэмж</b>		
<b>Нийгмийн халамжийн үйлчилгээ</b>	<b>79</b>	<b>1,503</b>
<b>Нийгмийн хөгжлийн үйлчилгээ</b>	<b>1,117</b>	<b>158,680</b>
<i>Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ</i>	1117	158,680
<i>Боловсролыг дэмжих үйлчилгээ</i>	0	-
<b>Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт</b>	<b>414</b>	<b>142,385</b>
<b>Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт</b>	<b>28</b>	<b>23,585</b>
<b>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт</b>	<b>197</b>	<b>28,673</b>
<b>Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж</b>	<b>3526</b>	<b>777377.8</b>
<i>0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж</i>	2598	608052.8
<i>Жирэмсэн эхийн тэтгэмж</i>	789	86032.2
<i>Ихэр хүүхдийн тэтгэмж</i>	4	8,000
<i>Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх,</i>	135	75,293
<b>Насны хишиг</b>	<b>2406</b>	<b>218,930</b>
<b>Нийт</b>	<b>14,583</b>	<b>3,326,275</b>

XIV. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 6-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ/аймгаар/  
2019.07.10

	Нэр төрөл	Дундговь	Төв	Өмнөговь	Дорноговь
1	Гурил, дээд зэрэг /Алтантариа/	1800.0	1406.0	1587.0	1433.0
2	Гурил, 1-р зэрэг /Алтантариа/	1200.0	1123.0	1350.0	1100.0
3	Гурил, 2-р зэрэг /Алтантариа/	1017.0	835.0	1200.0	900.0
4	Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай	833.0	746.0	1027.0	783.0
5	Талх, орон нутгийн үйлдвэрийн	1100.0	1283.0	1217.0	1433.0
6	Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/	2467.0	1300.0	2500.0	2067.0
7	Жигнэмэг /Юбилейные 150-180г, цайны/	1233.0	1267.0	1217.0	1200.0
8	Цагаан будаа, задгай, кг	2317.0	2367.0	2333.0	2267.0
9	Шар будаа, задгай, кг	3100.0	2650.0	3140.0	2767.0
10	Хонины мах, кг	8500.0	10000.0	8500.0	8833.0
11	Адууны мах, кг	-	9500.0	8000.0	8833.0
12	Ямааны мах, кг	8200.0	8500.0	7500.0	7833.0
13	Дотор мах, цувдай, цусгүй	2000.0	7000.0	2000.0	4000.0
14	Хиам чанасан, 1кг	9800.0	11777.0	10000.0	8100.0
15	Сүү, задгай, л	2500.0	1266.0	3000.0	2000.0
16	Сүү савласан,1л. Цэвэр сүү	2933.0	2800.0	2823.0	2833.0
17	Хорхой ааруул, задгай, чихэртэй	15000.0	15000.0	14500.0	15000.0
18	Өндөг,ш,дотоод	360.0	360.0	343.0	350.0
19	Ургамлын тос, 1литр, Кларина	3367.0	3783.0	3350.0	3167.0
20	Өөхөн тос, кг	-	1400.0	-	2000.0
21	Шар тос, кг	20000.0	20000.0	17000.0	17000.0
22	Цэцгийн тос, задгай, кг	-	4000.0	0.0	3500.0
23	Төмс дотоод, кг	1300.0	1200.0	1233.0	1167.0
24	Лууван хятад, кг	1300.0	1633.0	1367.0	1400.0
25	Байцаа хятад, кг	1925.0	1826.0	1500.0	1767.0
26	Сонгино хятад, кг	1300.0	1500.0	1467.0	1500.0
27	Элсэн чихэр, кг, орос	1883.0	1900.0	2100.0	2000.0
28	Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/	5467.0	5399.0	5600.0	5333.0
29	Зөөлөн чихэр, /Мишка/, кг	-	-	7000.0	9750.0
30	Шоколад, "Alpen gold"	2467.0	2466.0	2447.0	2267.0
31	Давс, цагаан, 1 кг, йоджуулсан	1000.0	996.0	800.0	750.0
32	Майноз, /Золотой 500г/	3667.0	4500.0	3797.0	4900.0
33	Кетчуп, 900г, Чили Полиш	1950.0	1900.0	2050.0	2000.0
34	Ногоон цай, Stimo, савласан 90г	1725.0	1686.0	1413.0	1300.0
35	Байхуу цай, Акбар, 20 ширхэгтэй	1720.0	1733.0	1597.0	1567.0
36	Цагаан архи, 0.5 Ерөөл	8667.0	8573.0	8733.0	8867.0
37	Пиво, "Боргио", 0.5л	1700.0	1593.0	1800.0	1650.0
38	Янжуур тамхи, /West/, саарал	3067.0	2833.0	2967.0	2800.0
39	Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи	2167.0	2043.0	2067.0	1880.0
40	Бензин, А-80, 1 литр	1890.0	1763.0	1930.0	1850.0
41	Бензин, А-92, 1 литр	1970.0	1827.0	2060.0	1960.0
42	Дизель түлш, 1 литр	2320.0	2340.0	2530.0	1460.0

ХV. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ (оны үнээр )

Аж үйлдвэрийн салбар	2019.07.10		мян.төг
	2018	2019	2019/2018 хувь
<b>Нийт дүн</b>	<b>3772886.6</b>	<b>4241119.9</b>	<b>112.4</b>
<b>Уул уурхайн олборлох аж үйлдвэр</b>	<b>956356.1</b>	<b>1268975.0</b>	<b>132.7</b>
Нүүрс олборлолт	181964.5	187369.0	103.0
Гөлтгөнө	151564.0	721106.0	-
Жонш олборлолт	622827.6	360500.0	57.9
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>516950.1</b>	<b>549818.6</b>	<b>106.4</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	449846.5	483858.4	107.6
Хуснэгт маягт үйлдвэрлэл	9975.1	10285.3	103.1
Боловсруулах үйлдвэр бусад	57128.5	55674.9	97.5
<b>Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж</b>	<b>2299580.4</b>	<b>2422326.3</b>	<b>105.3</b>
<i>Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл</i>	2000049.4	2056544.7	102.8
Ус ариутгал ус хангамж	299531.0	365781.6	122.1

#### XIV. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018 оны мөн үед	2019 онд	2019/2018 хувь
Хүрэн нүүрс	мян.тн	7.5	6.6	88.0
Жонш	мян.тн	3.6	1.1	30.6
Гөлтгөнө	мян.тн	6.1	5.3	-
Дулааны эрчим хүч	мян.гкал	45.1	49.7	110.2
Хүснэгт, маягт	х.д.х	142.4	146.8	103.1
Талх	тн	66.0	68.0	103.0
Нарийн боов	тн	51.1	61.4	120.2
Чихэр	тн	1.4	1.4	100.0
Архи	мян.л	14.8	12.5	84.5
Хиамны зүйл	тн	0.1	5.6	5600.0
Сүү, тараг	мян.л	3.0	4.5	150.0
Хоормог	мян.л	0.0	0.2	-
Ааруул	тн	0.2	7.7	3850.0
Вакум цонх	м <sup>2</sup>	70.0	0.0	-
Вакум хаалга	м <sup>2</sup>	27.0	0.0	-
Модон эдлэл	мян.төг	52560.0	52968.9	100.8
Түгээсэн цэвэр ус	мян.т <sup>3</sup>	54.0	68.0	125.9
Сувагжуулалт	мян.м <sup>3</sup>	36.6	45	123.0
Оёдол эсгүүр	мян.төг	30592.5	17590.0	57.5
Блок	мян.ш	2.0	1.3	65.0

## XVII. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ

2019.07.10

	2018 VI	2019 VI	19/18 хувь
Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо	30528	30616	101.6
Бүх хэрэг	158	112	70.9
Хүнийг санаатай алах гэмт хэрэг	2	0	0.0
Хүчиндэх гэмт хэрэг	5	4	80.0
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	6	1	16.7
Дээрэмдэх гэмт хэрэг	0	1	0.0
Булаалт	0	0	0.0
Танхайн хэрэг	0	0	0.0
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	43	18	41.9
Бусдын эд хөрөнгийн хулгай	63	32	50.8
Малын хулгай	10	24	240.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг	13	10	76.9
Залилангийн хэрэг	6	13	216.7
Албан тушаал	0	0	0.0
Бусад	10	9	90.0
Эмэгтэй хүн оролцсон	6	11	183.3
Согтуугаар	20	16	80.0
Бүлэглэж	12	5	0.0
Хүүхэд оролцсон	4	13	0.0
Илрээгүй хэрэг	88	56	63.6
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	5	4	80.0
Хөнгөн	95	87	91.6
Хүндэвтэр	0	0	0.0
Хүнд	63	25	39.7
Онц хүнд	0	0	0.0
Гэмт хэрэгт холбогдогсод	65	56	86.2
Учирсан бүх хохирол /сая.төг/	356.5	300.3	84.2
Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/	156.3	82.6	52.8
Илрүүлэлтийн хувь	38.0	46.2	121.6
18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/	52	37	71.2

ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ

2019.07.10

сум	18 ба түүнээс дээш насны хүн	18 -аас дээш насны 10000 хүнд ногдох	Бүх хэрэг	Холбогдогч	Хохирол /мян.төг/	Золгүй учрал	Хүн амь	хүчин	дээрэм	булаалт	танхай	бусдын бие махбодьд гэмтэл учруулсан	бусдын өмчийн хулгай	малын хулгай	лийн хөдөлгөөний аюулгүй байдлын	гал түймэр	албан тушаал	Залилан	бусад
Дэлгэрцогт	1129	53	6	2	18000.0								3	3					
Дэрэн	1380	72	10	1	59100.0							3	5	1				1	
Говь-Угтаал	1058	38	4	3	27925.2			1				3							
Цагаандэлгэр	699	43	3	2	2300.0			1											2
Баянжаргалан	819	49	4	1	5500.0							1	2					1	
Өндөршил	969	21	2	2	5500.0							1	1						
Гурвансайхан	1424	28	4	1	8500.0							3	1						
Өлзийт	1595	19	3	2	4500.0			1				1	1						
Хулд	1576	13	2		8500.0								2						
Луус	1231	49	6	4	26500.0							1	2	1					2
Дэлгэрхангай	1483	20	3	1	5345.0								1	1				1	
Сайхан-Овоо	1426	0	0																
Эрдэнэдалай	3721	8	3	1	12500.0	1							1						1
Сайнцагаан	10209	55	56	22	104733.0			1	1			14	11	10	5			10	4
Адаацаг	1897	32	6	3	11425.2								3	2	1				
Бусад	0			11															
Бүгд	30616	37	112	56	300328.4	1	0	4	1	0	0	18	32	24	10	0	0	13	9

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

[www.1212.mn](http://www.1212.mn)



Дундговь аймгийн  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



[www.dundgovi.nso.mn](http://www.dundgovi.nso.mn)

**Материалыг бэлтгэсэн:**

Т.Бямбасүрэн  
С. Доржханд  
Г.Ариунжаргал  
Н.Түвшинжаргал  
Б. Отгонсүрэн

Утас 70593714, 70593715

2019 оны 07 сарын 10

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Б.ЭНХТУЯА